



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ,
ДҮГНЭЛТ ГАРГАХ

**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**АУДИТЫН КОД:
ГНАГ-2024/15-
ШТА-НА-ОРА**

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088

Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805

Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70355805

Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үг2

Хүснэгтийн товъёг2

Дүрслэлийн товъёг2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл2

 Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:2

 Аудитын зорилт:2

 Аудитын хамарсан хүрээ:3

 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:3

 Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:3

Үндсэн мэдээлэл.....3

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛСАН БАЙНА.....4

 1.1 Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг 1319.1 мянган төгрөгөөр илүү хуваарилсан байна.....4

 1.2 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийн зардлыг үндэслэлтэй төлөвлөсөн байна6

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.6

 2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 11,741.86 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.7

 2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....8

 2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.9

Дүгнэлт Error! Bookmark not defined.

Холбогдох байгууллагын санал..... Error! Bookmark not defined.

Аудитын тайлан баталгаажуулах тушаал 11

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МТБ	Мэдээлэл технологийн баг
СНЖ	Сонгогчдын нэрийн жагсаалт
СХ	Сонгуулийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Зардлын гүйцэтгэл	4
2	Сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт	6
3	УБХ, Цагдаагийн газарт олгосон санхүүжилт	6
4	Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт	7
5	Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан	9

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Сонгуульд ажилласан албан хаагчид	4
2	СЕХ-с олгосон санхүүжилт	5
3	УБХ-ийн зардлын зарцуулалт	8

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн иргэдийн Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын тайлан”-д аудит хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн иргэдийн Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвөөс санхүүжүүлсэн зардлын тайланд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын сонгуулийн хороод, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Орхон аймаг дахь Цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлж, аудитор О.Гантуяа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2024 оны 11 дугаар сарын 05-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Үндсэн мэдээлэл


Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Хурлын сонгуульд Орхон аймгийн сонгуулийн хороонд 9 ажилтан, 2 сумын сонгуулийн хороонд 14 ажилтан, сонгуулийн 43 хэсгийн хороонд 387 ажилтан, 5 мэдээлэл технологийн ажилтан, 42 даамал, 5 нөөц даамал, 47 улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 148 албан хаагч, нийт 657 албан хаагч ажилласан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210022001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг аймгийн Сонгуулийн хорооны дарга М.Жанболат, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Отгончимэг хариуцан гүйцэтгэжээ.

Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210122001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны дарга Ш.Өлзийбаяр, 2

дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны гишүүн П.Отгонжаргал нар хариуцан гүйцэтгэсэн бөгөөд Жаргалант сумын Төрийн сангийн 100210222001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Жаргалант сумын сонгуулийн хорооны дарга Т.Энхжаргал, 2 дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны гишүүн Б.Отгонсүрэн нар тус тус гүйцэтгэсэн байна.

Дүрслэл 1. Сонгуульд ажилласан албан хаагчид /хувиар/



Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Орхон аймгийн сонгуулийн хорооны төсөвт 514,520.9 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн төсөвт 44,783.3 мянган төгрөг, Цагдаагийн газрын төсөвт 36,314.0 мянган төгрөг тус тус баталсан байна.

Бүлэг 1. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг үндэслэлтэй хуваарилсан байна.

1.1 Орон нутгийн сонгуульд Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг 1,319.1 мянган төгрөгөөр илүү хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 3 байгууллагад 595,618.20 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан, гүйцэтгэлээр 583,876.34 мянган төгрөгийг зарцуулж 11,741.86 мянган төгрөгийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 1. Зардлын гүйцэтгэл /мянган төгрөгөөр/


№	Байгууллагын нэр	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Орхон аймгийн сонгуулийн хороо	514,520.90	504,501.82	11,444.96
2	Улсын бүртгэлийн хэлтэс	44,783.30	44,486.40	296.90
3	Цагдаагийн газар	36,314.00	36,314.00	-
	Дүн	595,618.20	583,876.34	11,741.86

СЕХ-с Орхон аймгийн сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ төсвийн хуваарь, хуваарилсан төсвийн тайлбар, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

СЕХ-оос Орхон аймгийн сонгуулийн хороонд СХ-ны гишүүдийн урамшуулал, НДШ, хоолны зардалд 338,542.4 мянган төгрөг, МТБ, даамлын урамшуулал, НДШ, хоолны зардал мэдээ дамжуулах унааны зардал 67,089.2, маягт хэвлүүлэх, шуудан холбоо, бичиг хэргийн

зардалд 15,337.5 мянган төгрөг, томилолт, сургалт, сурталчилгаа, унааны зардалд 86,750.0 мянган төгрөг, саналын хуудас устгах, ЭХ-ний эх үүсвэрийн зардал 3,189.8, болзошгүй зардалд 3,612.0 мянган төгрөг, нийт 515,840.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дүрслэл 2. СЕХ-с олгосон санхүүжилт /төгрөгөөр/



СЕХ-ноос Орхон аймгийн сонгуулийн хороонд эхний санхүүжилтийг 2024 оны 08 сарын 01-ний өдөр хуваарилахдаа сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардлыг 300.0 мянган төгрөгөөр, МТБ, даамлын сургалтын зардлыг 1,019.1 мянган төгрөгөөр илүү олгосныг зарцуулж, буцаан төвлөрүүлсэн байна.

Орхон аймгийн сонгуулийн хороо нь 2 сумын сонгуулийн хороотой бөгөөд Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 40 хэсгийн хороо, Жаргалант сумын хэсгийн хороонд 3 хэсгийн хороо байгуулагдан ажилласан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооноос Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 359,644.8 мянган төгрөг, Жаргалант сумын сонгуулийн хороонд 33,352.6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

Хүснэгт 2. Сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Баян-Өндөр сумын Сонгуулийн хороо	Жаргалант сумын Сонгуулийн хороо	ДҮН
1	Бичиг хэрэг	5,000.00	560.00	5,560.00
2	Шуудан холбоо	6,150.00	600.00	6,750.00
3	Унаа	34,090.00	3,010.00	37,100.00
4	Санал авах байр бэлтгэх	12,632.00	947.40	12,147.40
5	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	272,652.80	25,603.20	274,736.00

6	Хоолны зардал	25,760.00	2,380.00	22,300.00
7	Болзошгүй зардал	3,360.00	252.00	3,612.00
	Нийт дүн	359,644.80	33,352.60	392,997.40

Орхон аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг тооцохдоо сумдын хүн амын тоо, хэсгийн хороодын байршил зэргийг харгалзан үзэж хуваарилсан байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 40 хэсгийн хороо ажилласан тул нягтлан бодогчийн орон тоо нэмж батлан санхүүжилтийг олгосон байна. Хэсгийн хороодод унааны зардал олгохдоо байршлыг харгалзсан бол бусад зардлыг СЕХ-с баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу хуваарилсан байна.

1.2 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлыг УБЕГ-ын төсөвт 2,546,740.5 мянган төгрөг, ЦЕГ-ын төсөвт 1,715,399.7 мянган төгрөг тус тус баталснаас Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 44,783.3 мянган төгрөг, Цагдаагийн газарт 36,314.0 мянган төгрөг хуваарилагдсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийг хуваарилахдаа хэсгийн хороо болон сонгуулиар ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны тоог харгалзан үзсэн бол Цагдаагийн газрын төсвийг сонгуульд ажиллах нийт бие бүрэлдэхүүний тоонд үндэслэн хуваарилсан байна.

Батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 3. УБХ, Цагдаагийн газарт олгосон санхүүжилт				/мянган төгрөгөөр/
№	Зардлын нэр	Улсын бүртгэлийн хэлтэс	Цагдаагийн газар	ДҮН
1	Бичиг хэрэг	2,730.30	-	2,730.30
2	Шуудан холбоо	-	9,890.00	9,890.00
3	Унаа /Шатахуун/	740.00	2,000.00	2,740.00
4	Хоолны зардал	-	24,424.00	24,424.00
5	Сургалт зохион байгуулах	6,450.00	-	6,450.00
6	Сургалтын бусад зардал	912.00	-	912.00
7	Шуурхай багийн зардал	1,336.00	-	1,336.00
8	Техник хэрэгсэл тээвэрлэх тээврийн хөлс	4,400.00	-	4,400.00
9	Шуурхай баг, нөөцийн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	28,215.00	-	28,215.00
	Нийт дүн	44,783.30	36,314.00	81,097.30

БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 11,741.86 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Орхон аймгийн сонгуулийн хороо нь 514,520.9 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 359,644.8 мянган төгрөгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд, 33,352.6 мянган төгрөгийг Жаргалант сумын сонгуулийн хороонд тус тус хуваарилж, 111,504.4 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хороо зарцуулж 10,019.0 мянган төгрөгийн хэмнэлтийг СЕХ-ны дансанд төвлөрүүлсэн байна. Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, буцаан

хүлээлгэн өгөх зардлаас 1,290.0 мянган төгрөг, МТБ, даамлын урамшуулал, хоолны зардлаас 463.2 мянган төгрөг, сурталчилгааны зардлаас 3,000.0 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 679.2 мянган төгрөг, томилолтын зардлаас 620.0 мянган төгрөг, шуурхай багийн зардлаас 1,530.0 мянган төгрөг, сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардлаас 3,452.4 мянган төгрөг, маягт хэвлэмэл хуудас хэвлэх зардлаас 2.7 мянган төгрөг, санал авах байрны түлшний зардал 300.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна. Илүү хуваарилсан сургалтын зардлын 1,319.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хорооноос 66.0 мянган төгрөг Жаргалант сумын сонгуулийн хорооноос 40.8 мянган төгрөг нийт 106.8 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн НДШ-ийн 2 хувийн хэмнэлтийг төвлөрүүлж бусад төсвийг бүрэн зарцуулсан байна. Зарцуулалтыг зардлын зүйл бүрээр дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Аймгийн СХ	Баян-Өндөр сумын СХ	Жаргалант сумын СХ	ДҮН
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	524.80	-	-	524.80
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2,610.00	-	-	2,610.00
3	МТБ, даамлын сургалт	3,574.08	-	-	3,574.08
4	Бичиг хэрэг	1,000.00	4,800.00	560.00	6360.00
5	Шуудан холбоо	820.75	6,150.00	600.00	7,570.75
6	Унаа	2,450.0	34,090.00	3,010.00	39,550.00
7	Санал авах байр бэлтгэх		11,200.00	840.00	12,040.00
8	Сурталчилгааны зардал	22,000.00	-	-	22,000.00
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ буцаан хүлээлгэн өгөх	16,320.00	-	-	16,320.00
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах, унааны зардал	1,300.00	-	-	1,300.00
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	14,224.00	272,586.80	25,562.40	312,373.20
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	34,716.00	-	-	34,716.00
13	Хоолны зардал	4,270.00	25,760.00	2,380.00	32,410.00
14	Томилолтын зардал	4,375.00	-	-	4,375.00
15	Шуурхай багийн зардал	1,670.00	-	-	1,670.00
16	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах		1,432.0	107.4	1,539.4
17	Саналын хуудас устгах зардал	1,649.8			1,649.8
18	Сурталчилгааны материал тараах унааны зардал				
19	Болзошгүй зардал	-	3,360.00	252.00	3,612.00
	Нийт дүн	111,504.43	359,378.80	33,311.80	504,195.03

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” А/136 дугаар тушаалаар Орхон аймгийн УБХ-т 44,783.3 мянган төгрөг хуваарилснаас 44,486.4 мянган төгрөгийг зарцуулан 296.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Бичиг хэргийн зардал хүрэхгүй талаар дээд шатны байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 10-ны 22/794 дугаартай албан бичиг явуулсан ч төсөв нэмэгдээгүй тул бичиг хэргийн зардлыг 1,184.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, шуурхай баг болон итгэмжлэгдсэн ажилтны урамшууллаас 1,331.8 мянган төгрөг, техник хэрэгсэл тээвэрлэх, шуурхай багийн зардлаас 150.0 мянган төгрөг нийт 1,481.8 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Зардлын зарцуулалтыг дүрслэлээр харуулав.

Дүрслэл 3. УБХ-ийн зардлын зарцуулалт

/мянган төгрөгөөр/



Орхон аймгийн Цагдаагийн газар нь “Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсөв”-ийн 36,314.0 мянган төгрөгөөс хоолны зардалд 24,424.0 мянган төгрөгийг, шуудан холбооны зардалд 9,890.0 мянган төгрөгийг, шатахууны зардалд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэний урамшууллын зардлаас 480.3 мянган төгрөг, хоолны зардлаас 56.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгасан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-д “Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого” гэж заасантай нийцэхгүй байна.
- Баян-Өндөр сумын сонгуулийн хороо 200.0 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоов.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын дагуу сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороо нэгтгэн тайлагнасан байна.

Хүснэгт 5. Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	527.50	524.80	2.70	0.09%
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	2310.00	2,610.00	-300.00	112.98%
3	МТБ, даамлын сургалт	2,555.00	3,574.08	-1,019.08	139.88%
4	Бичиг хэрэг	6,560.00	6,560.00	-	0.00%
5	Шуудан холбоо	8,250.00	7,570.75	679.25	91.76%
6	Унаа	33,530.00	33,530.00	-	0.00%
7	Санал авах байр бэлтгэх	12,040.00	12,040.00	-	0.00%
8	Сурталчилгааны зардал	25,000.00	22,000.00	3,000.00	88.00%
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ буцаан хүлээлгэн өгөх	17,610.00	16,320.00	1,290.00	92.67%
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах, унааны зардал	1,300.00	1,300.00	-	0.00%
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал, НДШ	338,542.40	335,090.00	3,452.40	98.98%
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал, НДШ	44,979.20	44,516.00	463.20	98.97%
13	Сурталчилгааны материал тараах унааны зардал	6,020.00	6,020.00	-	0.00%
14	Томилолтын зардал	4,995.00	4,375.00	620.00	7.62%
15	Саналын хуудас устгах зардал	1,649.80	1,649.80	-	0.00%
16	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	1,540.00	1,539.40	0.6	99.96%
17	Санал авах байрны түлшний зардал	300.00	-	300.00	
18	Шуурхай багийн зардал	3,200.00	1,670.00	1,530.00	52.18%
19	Болзошгүй зардал	3,612.00	3,612.00	-	0.00%
	Нийт дүн	514,520.90	504,501.83	10,019.07	98.05%

Баян-Өндөр сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод олгосон 200.0 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6-д "Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийг СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу сумдын сонгуулийн хороодод хуваарилсан байна. Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг аймгийн сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч, сумдын сонгуулийн хорооны зарцуулалтыг сумдын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа Төрийн санд нээлгэсэн сонгуулийн бүртгэлийн дансанд гарын үсгийн баталгаа гарган хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрын санхүүжилтийг тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн төвлөрүүлэн захирагчдын данснаас шилжүүлсэн бөгөөд зарцуулалтыг төсвийн шууд захирагч, ахлах нягтлан бодогчид 1, 2 дугаар гарын үсгийг зурж Төрийн сангийн хяналтад зарцуулагдсан байна.


Аудитын явцад сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын зарцуулалтын анхан шатны баримт материалтай танилцахад Орхон аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлыг СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу, бусад байгууллагын тухайд зарцуулалт хийхдээ дээд шатны төсвийн захирагчдаас ирүүлсэн тайлбар, чиглэлийн дагуу зарцуулсан байна.

Дүгнэлт

1. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг үндэслэлтэй хуваарилсан байна.
2. Орон нутгийн сонгуульд Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг 1,319.1 мянган төгрөгөөр илүү хуваарилсан байна.
3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.
4. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 11,741.86 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.
5. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
6. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН: АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

 О.ГАНТУЯА

 Б.БУЯН-УНДРАХ

Аудитын тайлан баталгаажуулах тушаал



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/102

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах" аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Баян-өндөр, Жаргалант сумын сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайлангаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулах арга хэмжээ авч, үр дүнг 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Сонгуулийн хорооны дарга (М.Жанболат), Баян-өндөр сумын Сонгуулийн хорооны дарга (Ш.Өлзийбаяр), Жаргалант сумын Сонгуулийн хорооны дарга (Т.Энхжаргал)-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), аудитор (О.Гантуяа) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 11 дүгээр сарын 01-ний
өдрийн А/12 дугаар тушаалын хавсралт

“Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон
улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт
гаргах” аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

/ мянган төгрөгөөр /

Дугаар	Зөрчлийн товч утга	Дүн	Шийдвэр	Хариуцах байгууллага
187/A1450340 OPA- 2024/15-ШТА-ГА	Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.	133.7	Төлбөрийн акт	Аймгийн Сонгуулийн хороо
188/A1450340 OPA- 2024/15-ШТА-ГА	Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.	196.6	Төлбөрийн акт	Баян-өндөр сумын сонгуулийн хороо
189/A1450340 OPA- 2024/15-ШТА-ГА	Арвилан хэмнэлтгүй зарцуулсан	200.0	Төлбөрийн акт	Баян-өндөр сумын сонгуулийн хороо
190/A1450340 OPA- 2024/15-ШТА-ГА	Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.	206.0	Төлбөрийн акт	Жаргалант сумын сонгуулийн хороо
Нийт дүн		736.3		